



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

**Байгууллагын нэр:** ШУТИС-ийн ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ

**Хөтөлбөрийн нэр:** ГЕОЛОГИ

**Индекс:** D053204

Шинжээчийн багийн ахлагч:

Ж.МӨНГӨН

Гишүүн:

Л.ЖАРГАЛ

Ц.НАРАНЦЭЦЭГ

Улаанбаатар хот

2023 он

# АГУУЛГА

## Товчилсон үгийн тайлбар

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

### II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

### IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

## I. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

## II. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

<b>Сургуулийн нэр</b> /Монгол, Англи/	Шинжлэх ухаан технологийн их сургууль Геологи уул уурхайн сургууль Mongolian university of science and technology School of geology and mining engineering	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b> /Монгол, Англи/	Геологи Geology	
<b>Индекс</b>	D053204	
<b>Шинжээчид</b>	Багийн ахлагч: Ж.Мөнгөн ХААИС-ийн Инженер технологийн сургуулийн захирал Гишүүн: Л.Жаргал МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Геологи, геофизикийн тэнхимийн профессор Гишүүн: Ц.Наранцэцэг Монголын ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Б.Соёлмаа: Магадлан итгэмжлэл, статистик хариуцсан шинжээч	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2023-11-21	Өөрийн үнэлгээний баг-Хөтөлбөрийн товч танилцуулга /ӨҮТ товч танилцуулга хийв.
		Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах
		Төгсөгчидтэй хийх уулзалт хийх
		Ажил олгогчидтой хийх уулзалт
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
		Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	2023-11-22	Шинжээчийн багийн уулзалт
		Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
		Оюутнуудтай хийх уулзалт
		Багш нартай хийх уулзалт
	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт танилцуулах	
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

### III. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн Геологи, гидрогеологийн салбар				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		1960				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		Геологи				
Хөтөлбөрийн индекс		D053204				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		960009, 2025 оны 03-р сар				
Сургалтын хэлбэр		Өдөр				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)		2022 он “Геологи” D053204				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		2016 он 06 дугаар сарын 27 ны өдөр				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		39				
Үүнээс	Үндсэн	39				
	Цагийн	-				
	Бусад	-				
Боловсролын зэрэг	Доктор					
	Магистр					
Албан тушаалын зэрэглэл	Профессор					
	Дэд профессор					
	Ахлах багш					
	Багш					
Ажлын туршлага	Дагалдагч багш					
	20-оос дээш жил					
	11-20					
	6-10 жил					
Суралцагчдын нийт тоо	5 хүртэлх жил					
		2022	2021	2020	2019	2018
Төгсөгчдийн тоо						
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль, Геологи, гидрогеологийн салбар, ШУТИС-ийн төв байр 11-326425, sers@must.edu.mn				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар		Г.Сэрсмаа				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Хоёр дах удаа				

## IV. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

*Тус хөтөлбөр нь Монгол улсын эдийн засаг, хөгжлийн тулгуур салбар болох уул уурхайн үндсэн инженер техникийн ажилтан судлаачийг бэлтгэж байгаа хөтөлбөр байна. Эрэлт хэрэгцээтэй тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр юм.*

- *Дэлхийн эдийн засгийн форум, Төрөөс уул уурхайн салбарын баримт бичгүүдэд геологийн салбарын талаар тусгасан байдал (Алсын хараа 2050), хөтөлбөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын судалгаа, төгсөгчийн ажлын байрны судалгаа хийсэн байна. STEEP шинжилгээ хийж түүндээ SWOT анализ хийж хөтөлбөрийн хэрэгцээт ур чадварыг тодорхойлсон байна.*
- *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанд судалгаа хийж ажил эрхлэлт хэрэгцээг тодорхойлсон байна.*
- *ХБНГУ-ын Фрайбергийн их сургуулийн геологийн хөтөлбөртэй харьцуулан судалсан байна.*
- *Тасис хөтөлбөрийн хүрээнд Фрайбергийн их сургуультай 1999 он болон 2000 онд хөтөлбөрийн харьцуулсан судалгааг хийж тайлан боловсруулсан байна.*

#### Шалгуурыг хангасан байдал: **БҮРЭН ХАНГАСАН**

#### Онцлог зүйл/Туршлага:

- *1960 оноос сургалт явуулж эхэлсэн бөгөөд хөтөлбөрийг тухай бүрд нь шаардлага эрэлт хэрэгцээг тодорхойлон уламжлалыг хадгалан хөгжүүлсэн тус сургуулийн урдаа барих шилдэг хөтөлбөр байна.*

#### Анхаарах асуудал:

- *Хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх төлөвлөгөө, энэ чиглэлээр бусдаас ялгарсан ирээдүйн төгсөгчийн загвар боловсруулаагүй байна.*

- ШУТИС болон МУИС-ийн хөтөлбөрүүдийг харьцуулахдаа хөтөлбөрөөр ур чадвар, агуулгыг харьцуулах болохоос сургуулийн зорилго зорилт, алсын харааг харьцуулах нь хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэхэд ямар ч ач холбогдолгүй юм.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг гадаадын 3-аас доошгүй хөтөлбөртэй харьцуулан судалж дүгнэх
- Хөтөлбөрийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, ШУТИС-ийн хөгжлийн хөтөлбөр, зорилго, зорилт болон Геологи, уул уурхайн сургуулийн зорилгод нийцүүлэн боловсруулсан байна. Сургууль хөтөлбөрийн зорилго, зорилтын уялдааг хангасан байна.
- Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлох уялдаа холбооны загвар зураглалыг боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ШУТИС-ийн төгсөгчийн хэв шинж, Монголын болон Олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага, CDIO-ийн суралцахуйн үр дүнгүүдийг үндэслэн тодорхойлсон байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг боловсролын чиглэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн боловсруулсан уялдаа хамаарлыг гаргасан сайн талтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилго зорилтыг Уул уурхайн талаар авч хэрэгжүүлж байгаа асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бодлогын баримт бичигтэй уялдуулсан зүйл тусгасан байдал харагдахгүй байна.
- Хөтөлбөр боловсруулалтын зорилго ШУТИС болон ГУУС-ийн эрхэм зорилготой уялдааг харуулсан хүснэгт 1.3 болон 1.4-ийн уялдаа харагдахгүй байна. Энд таарсан уялдааг харуулсан байдлаар харуулах

хэрэгтэй байна. Сургуулийн зорилттой харьцуулах болохоос эрхэм зорилготой харьцуулах нь зохимжгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг төрөөс баримтлах уул уурхайн бодлогын чиглэл, баримт бичиг, олон улсын мэргэжлийн байгууллагын зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулан тодорхойлох

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөрийг 1960 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд тухайн бүрийн боловсролын эрх бүхий удирдах байгууллагын шалгуур шаардлагын дагуу боловсруулан тухай бүрт сайжруулсан байна. 1996 оноос хойш 6 удаа шинэчлэн шалгуур шаардлагыг хангасан талаар тайланд тусгасан байна.
- 2009 онд МУ-ын стандартчилал хэмжил зүйн газраар геологийн мэргэжлийн хөтөлбөрийн MNS 5323-82: 2009 стандартыг баталгаажуулсан байна.
- 2011 онд магадлан итгэмжлүүлсэн. 2 удаа ахиц дэвшлийн тайлан өгч байнга шинэчлэн боловсруулж байсан байна.
- БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын дагуу хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, багц цагийг боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн хичээлүүдийн хамаарлыг ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн харилцан хамаарлыг гаргасан байна. Мөн суралцахуйн үр дүн суралцсан жил (курс) хамаарлыг харуулсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг цаг тухай бүрт нь шинэчлэн боловсруулсан байна.
- Мөн 2023 онд хөтөлбөрийн хороодоор хуралдаж шинэчлэл хийсэн бөгөөд энэ ондоо багтаж ШУТИС-ийн хөтөлбөрийн хороогоор баталгаажуулахаар ажиллаж байна.

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**



## Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хичээл болон суралцахуйн үр дүнгийн матрицыг харуулсан хүснэгтийг тайланд оруулсан байна.
- Хичээл хоорондын уялдаа холбоог харуулсан схемийн боловсруулсан байна.
- Үр дүнд суурилсан сургалтын дагуу төсөлд суурилсан хичээлүүдийг тодорхойлсон бөгөөд энэ нь хичээлийн нийт багц цагийн 6.9% байна.
- Сургалтын хөтөлбөрийн багц цагийн хувиарлалтыг тодорхой харуулсан байна.
- Хичээл хоорондын уялдаа холбоог маш сайн тусгасан бөгөөд үүнийг тодорхойлох хамаарлын матриц зураглал гаргасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### Онцлог зүйл:

- Сургалтын хөтөлбөрөөр олгох ур чадвар болон хичээлийн уялдаа холбоог хийж, хичээл бүрээр олгох ур чадварыг хичээлийн хөтөлбөрт оруулж жил бүр сайжруулж баталгаажуулдаг байна.

#### Анхаарах асуудал:

- БСШУЯ-ны сайдын А/174 тоот тушаалын шаардлагыг багц цагийн хувиарлалт хангахгүй байна.

#### Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөг хөтөлбөрт тавигдах шаардлага, холбогдох журмыг баримтлан бүтцийн хувьд оновчтой төлөвлөх

## 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### Илрэл нотолгоо:

- Үр дүнд суурилсан сургалтыг хөгжүүлэх 6-н сургалтын заах аргыг ашигладаг нь хичээлийн хөтөлбөрүүдэд тусгагдсан байна.
- Сургалтыг танхим, цахим, дадлага гэсэн хэлбэрээр хүргэдэг бөгөөд ихэнх хичээлийн лекц нь тонгоруу сургалтын аргыг ашигладаг байна.
- Хөтөлбөрийн өөрийн онцлогоос хамаарч сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг өөрийн дадлагын баазад биет, байгаль дээр зураглалд үйлдэх болон танин мэдэх байдлаар кейст суурилсан сургалтыг ашигладаг байна.
- Геологи, эрдэс баялгийн музейд геологич хүний танин мэдэх мэдлэгүүдийг олгох биет үзүүлэнд суурилсан сургалтыг явуулж байна.

### Шалгуурыг хангасан байдал: **БҮРЭН ХАНГАСАН**

### Онцлог зүйл:

- Хичээл бүрийн хөтөлбөрт идэвхтэй сургалтын арга зүйг тусган хэрэгжүүлдэг сайн талтай байна.
- Үйлдвэрлэлийн дадлагыг манай улсын хамгийн том уул уурхайн компани болон судалгааны төвүүдэд хийдэг юм байна.
- Мэргэжлийн түвшинд хэрэглэгддэг программ хангамжуудыг бүрэн ашиглаж сургалт явуулдаг байна.

### Зөвлөмж:

- Сургалтын үйл ажиллагаандаа виртуал сургалтын үзүүлэн, орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан шинэлэг арга зүйг ашиглах

## 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### Илрэл нотолгоо:

- Суралцагсдад төвтэй суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд дэмжлэг үзүүлэх хэлбэрээр мэргэжлийн ёс зүйг дээдлэн хөгжүүлдэг байна.
- Үр дүнд суурилсан сургалтын CDIO арга зүйг хэрэгжүүлж байна.

- Суралцагчийн үнэлгээний талаар 70%+30% үнэлдэг бөгөөд 70%-ийн задаргаа болон суралцагчийн үнэлгээг тайланд оруулсан байна.
- Хөтөлбөрөөр суралцагчийн үнэлгээний голч дүнг үзүүлсэн энд хавар амжилттай суралцдаг намрын сурлагын амжилт арай бага байгаа талаар тайланд тусгасан байна.
- Хичээлийн хөтөлбөрүүдэд 70%-ийг ямар даалгавар хийж гүйцэтгэх талаар тусгаж оруулсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл:**

- Хичээлийн хөтөлбөрт идэвхтэй сургалтын арга ашиглах талаар тусгаж, үнэлгээг оруулж өгсөн байна.
- Зарим хичээлд хөтөлбөрөөр олгох ур чадварыг Блуын таксономи, Рубрик арга ашиглан үнэлэх талаар арга зүйг тусгаж оруулсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Үр дүнд суурилсан сургалт, заах арга зүйг хэрэгжүүлж ахиц гарсан судалгаа авч хичээлийн хөтөлбөрийг сайжруулах хэрэгтэй.
- Тухайн идэвхтэй сургалтын арга уг хичээлд тохирч байгаа эсэхийг тодорхойлж бусад багш нарт жишээ болгон хөгжүүлэх хэрэгтэй.
- Үр дүнд суурилсан сургалтыг хэрэгжүүлж байгаа гэсэн боловч ур чадварыг дүгнэх талаар тайланд ямар нэгэн байдлаар тусгаагүй байна.
- 2023 оны шинэчилсэн хөтөлбөр буюу тайланд тусгасан хөтөлбөрөөр олгох ур чадвар хичээлээр олгох ур чадварууд зарим тал дээр алдаатай дутуу боловсруулагдсан байна

#### **Зөвлөмж:**

- Шинэчилсэн хөтөлбөр буюу тайланд тусгасан хөтөлбөрөөр олгор ур чадвар, хичээлээр олгох ур чадваруудын уялдаа холбоог хангах
- Хөтөлбөрөөр олгох ур чадварыг Блум таксономийн үйл үг ашиглан үнэлэх хэрэгтэй бөгөөд бакалаврын түвшинд 3 түвшний үйл үгнүүдийг ашиглан үнэлгээ хийдэг байхаар хичээлийн хөтөлбөрүүдэд тусгах

### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ШУТИС-ийн ГУУС-ын Геологи, гидрогеологийн салбар нь лекц, лаборатори, семинарын хичээлийн 8, сургалт-судалгааны 9, судалгааны төв болон судалгааны лабораторийн 8, багш ажилчдын 8, нийт 33 анги, танхимын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа нь нийт суралцаж буй оюутнуудын хувьд хүрэлцээтэй байна. Эдгээр анги танхимын тохижилт, эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдал нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандартууд болон хөдөлмөрийн хуулинд заагдсан нөхцөлүүдийг ханган ажиллахад бүрэн бололцоотой. 1 оюутанд ноогдох талбай хичээлийн анги, танхимуудад дунджаар 1.49 м<sup>2</sup>, лабораториудад 3.42 м<sup>2</sup> байх бол нэг багшид ноогдох багшийн өрөө дунджаар 8.65 м<sup>2</sup> байгааг бодит судалгаа харуулж байна.
- Мөн эрүүл мэнд, урлаг спортын үйл ажиллагаа явуулах төвүүд болон багш, оюутнуудад зориулсан цайны газрууд ажиллуулдаг нь тэдэнд сурч хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлж байна.
- Оюутнуудын сургалт судалгааны зориулалттай минералогийн, хүдэр судлалын, палеонтологийн, петрографийн, геофизикийн мэдээлэл боловсруулах, гидрогеодинамик загварчлалын, грунтын механикийн туршилтын зэрэг олон тооны хичээлийн лабораториудаас гадна дээж бэлтгэлийн, байгалийн нөөц судлалын, бодисын шинжилгээний зэрэг судалгааны лабораториудыг ажиллуулдаг. Ялангуяа орчин үеийн дэвшилтэт технологи болох сканнинг электрон микроскоп (SEM), ойсон болон нэвтэрсэн гэрлийн микроскоп бүхий МЕТА бодисын судалгааны лабораторийг шинээр байгуулан холбогдох тоног төхөөрөмжийг суурилуулан тохижуулсан. Мөн ормын болон эрдсийн бүрэлдэхүүний судалгааг иж бүрэн явуулах боломжтой ойсон болон нэвтэрсэн гэрлийн микроскоп, бусад багаж хэрэгсэл бүхий байгалийн нөөц судлалын лаборатори, мөн эрдсийн болон хийн хроматографийн судалгаа явуулах боломж бүхий тоног төхөөрөмж суурилуулсан ШУТИС, Нагоя их сургуулийн

хамтарсан хээрийн судалгааны төвийн лаборатори зэргийг байгуулан ажиллуулж оюутны сургалт, судалгаанд ашиглаж байгаа.

- Мэдээллийн технологийн хэрэгслийн хувьд 46 компьютер бүхий 2 лабораторитой, мөн сургалт явуулахад шаардлагатай проектор, дэлгэцүүд анги танхимд байрлуулсан. Ялангуяа геофизикийн боловсруулалтын танхимд бүрэн хэмжээний засвар үйлчилгээ хийж тохижуулан оюутнуудын сургалтад зориулсан 64 инчийн ухаалаг дэлгэц самбарт байрлуулсан нь багш сурагчдад чухал ач холбогдолтой болсон.
- Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаанд тухай бүр дүн шинжилгээ хийж 3-4 өрөөний дунд утасгүй интернет төхөөрөмж суурилуулснаас гадна сургуулийн орчинд утасгүй интернетийн бүстэй болсон нь оюутнуудад интернет ашиглан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.
- Оюутны бие даалтын танхимын хүчин чадлыг нэмэгдүүлэн 100 оюутанд хүртээмжтэй болгосноос гадна 24 цагийн бие даалтын танхимыг бий болгож амрах хэсэг, халуун, хүйтэн ус, хоол унд халаах төхөөрөмж, хөргөгч зэргийг суурилуулан тохижуулсан нь оюутнуудын чөлөөт цагаараа бие даан сурч боловсрох, мэргэжлийн ангийн оюутнууд хамтран төсөл, хөтөлбөр, бие даалтын ажлуудаа багаар суун хамтран гүйцэтгэх зэрэгт өргөн ашиглагдаж байгаа.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутнуудад геологийн мэргэжлийн номын сан, бие даалтын танхимтайгаас гадна тэдэнд мэргэжлийн чиглэлээр ихээхэн хэмжээний мэдлэг авах боломж бүхий Геологи, эрдэс баялгийн музейтэй байгаа нь тус сургалтын хөтөлбөрийн онцлог юм. Энэхүү геологийн музей нь Монгол орны геологийн тогтоцын талаар зураг, тайлбар, ханын самбар, тусгай булантайгаас гадна нутаг дэвсгэрийн хэмжээнд тархалттай чулуулаг, эрдэс, ашигт малтмал, өнгөт эрдэнийн чулууны нийт 3000 орчим дээж, үзмэрүүдийг агуулдаг нь сурагчдад хичээлээр үзсэн онолын мэдлэгийг баталгаажуулах, хүссэн чиглэлээр нэмэлт мэдээлэл авах зэрэг олон талын ач холбогдолтой. Мөн энд ГУУС-ийн геологи, минералоги, ашигт малтмалын чиглэлийн хичээлүүдийг заах боломжтой бөгөөд тус хөтөлбөрийн оюутнуудаас гадна геологийн чиглэлээр сургалт явуулдаг бусад их, дээд сургуулиудын оюутнууд ирж танилцах, хичээл заалгах боломжоор хангагдсан байдаг. Энэхүү музейг шинэчлэх, шинэ үзмэрүүдээр баяжуулах чиглэлээр музей хариуцсан ажилтан идэвх санаачилга гарган ажилладаг.

### **Анхаарах асуудал:**

- *Анги, танхимуудын засвар үйлчилгээг шат дараатай хийхээр төлөвлөж байгаа боловч нэгдсэн журмаар бүгдийг хамруулах санхүүгийн боломжгүй, нийт 33 анги, танхимын 10-аас бусдын засвар үйлчилгээ 2020 оноос өмнө хийгдсэн, 2023-2024 онуудад засвар хийх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, хандив тусламж хүсэх ажлуудыг зохион байгуулсан боловч үр дүн одоогоор тодорхойгүй.*

### **Зөвлөмж:**

- *Оюутны бие даан болон багаар ажиллах орчны хангалтыг сайжруулах, цахим орчинд интернетийн хурдыг сайжруулах*

## **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- *Мэргэжлийн чиглэлийн гол багаж болох ойсон болон туйлширсан гэрлийн нийт 15 микроскоп бүхий минералоги, петрографийн лабораториудаас гадна геологи, палеонтологи, стратиграфи, түүхэн геологи, металл ба металл бус ашигт малтмалын зэрэг олон тооны кабинетуудыг байгуулан холбогдох тоног төхөөрөмж, мэргэжлийн программуудаар хангаснаас гадна эрдэс, чулуулгийн дээж, шлиф, аншлиф, фаун ба фоссил үлдвэрүүдийн дээж зэрэг биет материалуудаар хангасан байна.*
- *Мэргэжлийн сургалт, судалгаанд хэрэглэгддэг Micromine, Map Info, Surpac, Aquachem, Mathlab, Geosoft зэрэг лицензтэй 11, ArcGIS, Tridraw, Auto cad зэрэг лицензгүй 11, нийт 22 программаар оюутан, багш нар хангагдсан. Бүх багш нар хичээлээ цахим хэлбэрт оруулсан, улирал тутам шинэчлэлт хийдэг тул аливаа эрсдэлт нөхцөл байдалд хичээлээ оюутнуудад цахимаар хүргэх бүрэн боломжтой.*

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- *Оюутнуудын геологийн хээрийн танилцах дадлага, структур геологи ба зураглалын дадлага хийх 2 суурь бааз – полигонтой, тэндээ тодорхой төлөвлөгөөтэй сургалтуудыг зохион байгуулдаг.*
- *Мэргэжлийн чиглэлийн олон тооны лицензтэй программ хангамжуудыг сургалтдаа ашигладаг.*

### **Анхаарах асуудал:**

- *Оюутны геологийн сургалт, үйлдвэрлэлийн дадлагын хугацааг уртасгах боломжийн талаар судлах*

### **Зөвлөмж:**

- *Геологийн мэргэжлийн чиглэлийн сургалтын цахим контентүүдийг олшруулах*

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- *ГУУС-ийн Геологи хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд нь ШУТИС-ийн нэгдсэн номын сан болон ГУУС-ийн номын сан, тус бүр 460 ба 80 суудалтай оюутны уншлагын танхимууд, Е-уншлагын танхим, онлайн төстийн танхимууд зэргээр үйлчлүүлэх бүрэн боломжтой. Тус нэгдсэн номын сан геологийн мэргэжлийн ба ерөнхий эрдмийн 9507 ном, сурах бичгээр оюутнуудад үйлчилгээ үзүүлдэг. Энэхүү номын сан нь оюутнууддаа электрон картаар үйлчилдэг, электрон каталогт нь геологи, уул уурхайн чиглэлээр 1844 төрлийн 7343 сурах бичиг, магистр, докторын судалгааны ажил бүртгээгдсэн байдаг (<https://lib4u.net/?lib=must>).*
- *Мэргэжлийн хичээлүүдийн 85-90% нь үндсэн сурах бичигтэй. Хөтөлбөрийн багш нар сүүлийн 5 жилд 14 ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн. Монгол, англи, орос хэл дээр хэвлэгдсэн “Геологи”, “Хайгуулчин”, “Mongolian Geoscientist” болон бусад мэргэжлийн сэтгүүлүүдийг оюутнуудад зориулж архивлан хадгалдаг.*
- *Оюуны өмчийг хамгаалах, бүтээлийн хуулбарлалтыг шалгах чиглэлээр 2022 оноос эхлэн доктор, магистрийн нэг сэдэвт бүтээлүүдэд оюуны өмчийн хуулбарлалтыг тусгай программ “Plagscan”, “Turnitin” зэрэг зориулалтын программууд ашиглан шалгаж эхэлсэн. Энэ нь зөвхөн магистр, докторын зэрэг горилсон ажлуудад төдийгүй багш нарын боловсруулсан эрдэм шинжилгээний өгүүлүүдэд хяналт хийхэд ашиглагдах бүрэн боломжтой. Тус программын нэгдсэн баазад олон улсад англи хэл дээр хэвлэгдсэн бүхий л мэдээллүүдээс гадна ШУТИС-ийн судалгааны сангийн 6500 орчим магистр, докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлүүд байдаг.*

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл:**

- Номын сангаар дамжуулан ШУТИС-ийн тусгай нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан Scopus-ийг төлбөргүйгээр ашиглаж олон улсын мэргэжлийн нэр хүнд бүхий сэтгүүлүүдэд англи хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн хураангуй, бусад мэдээллүүдийг дэлгэцээр харах, уншиж танилцах боломжтой байдаг нь багш нарт мэргэжлийн талаар бий болоод байгаа шинэлэг мэдээллүүдтэй танилцах, оюутнуудад танилцуулах боломжийг олгож байгаа.

**Анхаарах асуудал:**

- Энэ бүх мэдээллийг бакалавр оюутнууд хэрхэн ашиглаж байгааг хянах боломж бүрдүүлэх.

**Зөвлөмж:**

- Оюутны эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх, үүнтэй холбоотойгоор номын сан, цахим мэдээллүүдийг ашиглахад оюутнуудын идэвх санаачилгыг сайжруулах

**3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**



## Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- *Сургалтын хөтөлбөрийн аливаа өөрчлөлт шинэчлэлийг салбарын профессорын баг, тэнхим, салбарын хурлаар эхлэн хэлэлцэж Хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулж хийдэг бөгөөд холбоотой оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа, сургалтын хөтөлбөрийн үр дүнг үнэлэх төгсөгч оюутны судалгаа зэргийг тодорхой хугацаанд авч үйл ажиллагаандаа тусгадаг. Мөн оюутнуудын санал, хүсэлт, гомдлыг хайрцаг, мэйл, болон бичиг зэрэг бүхий л хэлбэрээр хүлээн авч тодорхой үе шаттайгаар шийдвэрлэдэг. Чанарын менежер хагас жил тутамд санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг хянадаг тогтолцоог бүрдүүлсэн.*
- *Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай нийт 19 дүрэм, журмыг боловсруулан батлуулж мөрдөж байгаа. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт (ШУТИС-2030), дунд (ГУУС-2030) ба богино (ГУУС-ийн жил жилийн төлөвлөгөө) хугацааны төлөвлөгөө боловсруулан батлуулж гүйцэтгэлийг санхүүгийн жилээр гаргадаг, хэрэгжилт болон тайлангийн гүйцэтгэлд чанарын менежер хянан хяналт үнэлгээ хийдэг.*
- *Удирдлага мэдээллийн систем –UNILIMS багшийн вебсайт тогтмол ажиллуулж хэвшсэн ба эндээс оюутан ба багш нар удирдлага, мэдээлэлтэй холбоотой бүхий л мэдээллийг авах боломжтой:*

#### Шалгуурыг хангасан байдал: **БҮРЭН ХАНГАСАН**

#### Онцлог зүйл/Туршлага:

- *Удирдлага мэдээллийн систем –UNILIMS багшийн вебсайт тогтмол ажиллуулдаг. Мөн Microsoft TEAMS программыг албан ёсны эрхтэйгээр ашиглаж цахим сургалтын анги хичээллүүлэх, хурал, уулзалт зохион байгуулах, мэдээлэл дамжуулах зэрэг ажлуудыг явуулдаг.*
- *Багшийн хувийн мэдээлэл, хичээлийн хуваарь зэргийг харах, хянах, яаралтай үед ашиглах MUST PROFESSOR гар утасны аппликейшныг ашигладаг.*

### **Зөвлөмж:**

- *Оюутнуудын тоо цөөрч байгаатай холбоотойгоор Геологийн мэргэжлийг сурталчлах, хүүхэд залуусын сонирхлыг татах зорилгоор геологийн мэргэжлийн сурталчилгааг цахим хуудсаараа дамжуулан явуулах ажлыг эрчимжүүлэх*

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- *Хөтөлбөрийн багш нар сүүлийн жилүүдэд “Субдукцийн бүсийн геологи, магматизм”, хүдэржилтийн судалгаа, хэтийн төлөв’, Нуурын бүсийн палеозойн магматизм, геодинамик хөгжил, хүдэржилт, ашигт малтмал”, “Тогтохшил гүний маагмын бүрдлийн гарал үүсэл, геодинамик орчин, зэсийн хүдэржилт” зэрэг ШУТС-аас санхүүжсэн суурь судалгааны 4 төсөл болон бусад эх үүсвэртэй нийт 7 төслийг хэрэгжүүлж дуусган гүйцэтгэлийн тайланг боловсруулан захилагчид тушааснаас гадна “Хүрээлэгч орчны бохирдлын хяналтын цогцолбор судалгаа, тогтвортой хөгжил: Төв Монголын Туул, Хараа голын ай савуудын жишээн дээр” зэрэг 2 төсөл үргэлжлэн хэрэгжиж байгаа байдалтай байна.*
- *Давхардсан тоогоор 16 багш Мянмар, АНУ, Япон, Энэтхэг, Хятадын геологийн эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудад 10 хоноогоос 2 жилийн хугацаагаар ажиллаж мэргэжил дээшлүүлснээс гадна 4 багш Олон улсын геологийн чиглэлийн нэр хүнд бүхий сэтгүүлүүдийн редакцын Зөвлөлд ажиллаж ирсэн.*
- *Гадаадын геологийн мэргэжлийн их сургуулиудтай холбоо тогтоон хамтран ажиллаж өөрсдийн оюутныг илгээн дадлагажуулах, мөн тухайн байгууллагын оюутнуудыг өөрсдийн хээрийн судалгааны ажилд оролцуулан дадлагажуулах, мөн геологийн бакалавраар төгссөн 10 шахам оюутныг (Т.Номин, Б.Манзшир, Д.Отгонбаяр ба бусад) Японы Тохокугийн Их сургуульд магистрийн судалгаан ажлыг хийлгэх, хамгаалуулахаар илгээсэн нь амжилттай төгсөж зарим нь дараагийн шатны сургалтад хамрагдсан бол зарим нь Монголын Геологийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байна.*
- *Геологи хөтөлбөрийн багш нар сургуульдаа 16-32 жил ажилласан, сургах заах аргазүй, судалгаа, нийгмийн хариуцлагын хувьд өндөр түвшний багш нар бөгөөд 70% нь Монгол Улсын Зөвлөх Геологич цолтой, Монголын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл, Монголын Стратиграфийн Комисс, ШУА-ийн Бага чуулган, Монголын Геологийн нэгдсэн Холбоо зэрэг Монгол орны*

геологийн асуудлаар тодорхой дүгнэлт, үнэлгээ, зөвлөлгөө өгөх эрх, үүрэг бүхий мэргэжлийн орон тооны бус байгууллагуудад гишүүнээр ажилладаг. Мөн хөтөлбөрийн багш нар Монголын Үйлдвэрлэлийн Геологичдын Холбооноос жил бүр уламжлал болон зохион байгуулдаг Round Up геологийн эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийг холбосон онод практикийн бага хурлын зохион байгуулалтад ажиллах, өөрсдийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэн нийтийн хүртээл болгох, оюутнуудаа удирдан оролцуулах, хурал удирдах зэргээр оролцдог.

- Геологи хөтөлбөрийн багш нар төгсөгчдийн давтан сургалтыг тав таван жилийн давтамжтайгаар сургадаг уламжлалтай байсан бөгөөд харин сүүлийн жилүүдэд Монголын Геологийн Холбоодын Нэгдсэн Зөвлөлөөс зохион байгуулдаг “Монгол Улсын Зөвлөх Геологич”, “Монгол Улсын Мэргэшсэн геологич” нарт зориулсан сургалтуудад мэргэжлийн чиглэлээрээ мэргэшүүлэх хичээл заах, шалгалтыг зохион байгуулах хэлбэрээр энэ үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байгаа. Энэ сургалт, шалгалтын ажил жилд 1 удаа геологийн зураглал, эрэл хайгуул зэрэг чиглэлүүдээр тус тус зохион байгуулагддаг.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн багш нар Геологийн зураглал, эрэл хайгуул, ашиглалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай болон үндэсний компаниудтай хамтран ажиллах ажлын хүрээнд оюутнуудад зориулсан сургалтын тэтгэлэг олгох талаар санамж бичиг байгуулан ажилладаг. Жишээлбэл, энэ ажлын үр дүнд 2023 оны 5-р сард гадны хөрөнгө оруулалттай “Онтрэ “ ХХК Геологийн салбарын 10 оюутанд 1 жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.

#### **Анхаарах асуудал:**

- Ковид цар тахлын улмаас түр тасарсан оюутан солилцооны хөтөлбөрийг сэргээх, үргэлжлүүлэх тал дээр санаачилга гарган ажиллах

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийг давтан сургах үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар явуулдаг байсан уламжлалыг сэргээх боломжийг судлах, явуулах

### **4.3. Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

## **Илрэл нотолгоо:**

- Жил бүр салбарын төсвийн саналыг хэлэлцэж ГУУС-ийн төсөвт тусгадаг бөгөөд ШУТИС–ийн нэгдсэн санхүүгээс хийсэн төсвийн хуваарилалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.
- Геологийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай хамтран ажиллаж өөрсдийн оюутнуудыг геологийн үйлдвэрлэлийн дадлага хийлгэх боломжийг бүрдүүлэн ажилладаг.
- Үйл ажиллагааны үндсэн орлогоос бусад буюу сургалтын төлбөрөөс гадна геологийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн төсөл, гэрээт ажлуудын санхүүжилт, мөн ажиллуулж буй Геологийн судалгааны төвүүдийн үйл ажиллагаа зэргээс нэмэлт орлого бүрдүүлдэг. Жишээлбэл, 2019 ба 2023 оны хооронд хэрэгжүүлсэн 5 төсөл болон төвүүдийн орлого, нийт 25.4 мян.төг орлого олсон.
- Орлогыг шууд захиран зарцуулдаггүй, ШУТИС–ийн нэгдсэн санхүүгээс хийсэн төсвийн хуваарилалтын дагуу ажилладаг. Сургалтын төлбөр хөтөлбөрт 100% зарцуулагддаг.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, сурагчийн хөгжилд зарцуулагддаг.
- Оюутны геологийн үйлдвэрлэлийн дадлага болох Ерөнхий геологи, Структур геологи, болон сургалт-үйлдвэрлэлийн дадлагуудад хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь зарцуулагддаг бөгөөд энэ хэмжээ жил тутам өсөн нэмэгдэж байгаа (2019 оныг эс тооцвол).
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 03-р сарын 29-ний өдрийн 115 -р тогтоолоор Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад “Геологи” мэргэжил багтах болсноор оюутнууд Боловсролын зээлийн сан, Оюутны хөгжлийн зээлд хамрагдах бүрэн боломжтой болсон.
- Оюутолгой ХХК, Эрдэнэс таван толгой ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Зориг сан, Мицубиши корпорацийн Олон улсын тэтгэлэгт хөтөлбөрүүдэд Геологийн оюутнууд хамрагдах бүрэн боломжтой бөгөөд энэ нь ГУУС-ийн санхүүжилтэд хувь нэмэр оруулдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Геологийн мэргэжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээс сургалтын хөтөлбөрт зарцуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын орчныг сайжруулахад санхүүгийн хувьд хязгаарлагдмал байгааг анхаарах

#### **Зөвлөмж:**

- Геологийн мэргэжлийн чиглэлээр багш нарын бий болгосон гарын авлага, сурах бичгүүдийг олшруулах, төгсөгчид, геологичдод зориулан агуулгыг

өргөжүүлэх, хэвлэх, худалдах замаар тодорхой хэмжээний орлогыг бий болгох

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Багш нар мэргэжлээ сурталчлах ажилд идэвхтэй оролцож “ШУТИС-ТУР” уулзалт семинар, “Боловсролын үзэсгэлэн яармаг” зэргийг зохион байгуулснаас гадна АМЕР төслийн хүрээнд хөдөө орон нутгийн арван жилийн сургуулийн сурагчдад мэргэжлээ тайлбарлан таниулсан.
- Геологи хөтөлбөрөөр төгсөгчид дагнан МРТИ цахим платформыг хөгжүүлж Геологийн чиглэлийн тэргүүлэх эрдэмтэд, залуу эрдэмтэн судлаачдын судалгааны ажлыг нийтийн хүртээл болгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа.

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Геологийн хөтөлбөрийн багш нар Ерөнхий редактор ба Редакцийн гишүүдээр нь ажилладаг “Mongolian Geoscientist” сэтгүүл нь Mongolia Journal Online платформд программд бүртгэлтэй Монголын Геологийн салбарын анхны онлайн сэтгүүл бөгөөд олон улсын сэтгүүлд тавигдах шаардлагыг хангасан, мэргэжлийн түвшин хянагддаг, бүтээлүүд нь DOI дугаартай хэвлэгддэг. 2023 онд Scopus олон улсын бүтээлийн санд бүртгэлтэй болсон.

##### **Анхаарах асуудал:**

- Оюутны тоог нэмэгдүүлэх,

##### **Зөвлөмж:**

- Оюутнуудын тоо цөөрч байгаатай холбоотойгоор арван жилийн сургуулийн ахлах ангийн сурагчдад геологийн мэргэжлийн сурталчилгааг цахим хуудсаараа дамжуулан явуулах ажлыг эрчимжүүлэх, ялангуяа мэргэжлийн чиглэлийн танилцуулга-цахим контентүүдийг бий болгон сурталчлах

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч Геологи, Гидрогеологийн салбар нь сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг ГУУС-ийн цахим хуудсанд байршуулдаг (<http://guus.edu.mn/mn/page/394>).
- Хөтөлбөрт өөрчлөлт шинэчлэлийг тухай бүр хийж оюутнуудад сургууль, салбарын бүтэц, багш нарын танилцуулга, мэргэжлийн хичээлүүдийн төлөвлөгөө, стандарт, оюутны сурах үйл ажиллагааны заавар, үнэлгээний систем, сургалттай холбоотой дүрэм, журмуудыг тусгасан гарын авлага бэлтгэн хүргүүлдэг. Мөн элсэгчдэд тавигдах шаардлага, хөтөлбөр, мэргэжлийн онцлогийн талаар мэдээлэл бэлтгэн жил бүр сайжруулалт хийж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС ба ГУУС нь сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг авах боломжтой вебсайтыг тогтмол ажиллуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн сурталчилгааг өргөжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Нийгэмд геологийн мэргэжлийн талаарх үнэн зөв ойлголтыг өгөх чиглэлээр цахим контентүүдийг бий болгон сурталчлах

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журмыг Дээд боловсролын тухай хуулийн 7-р зүйлийн 7,3 заалт, БСШУ сайдын 2013 оны А/79, 2018 оны А/195 тоот тушаалуудыг үндэслэн “Оюутан элсүүлэх журам”-ыг жил бүр шинэчлэн баталж хэрэгжүүлдэг, хамгийн сүүлд 2022-2023 онд оюутан элсүүлэх журмыг шинэчлэн боловсруулж элсэлтийн үйл ажиллагааг явуулжээ.
- Шинэ элсэгчд нь цахим хаягаар (<https://must.edu.mn/media/uploads/2022/04/18/elselt-juram-2022-khuraangui.pdf>), <https://elselt.edu.mn/> болон сургалтын албаар дамжуулан салбарын эрхлэгч, зөвлөх багштай биечлэн холбогддог байна. Суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ нь” оюутны нэгдсэн үйлчилгээний хуанли”-г гаргаж шинэ элсэгчдийг мэдээллээр ханган ажилладаг. Оюутны нэгдсэн үйлчилгээний хуанлид тусгагдсаны дагуу жил бүрийн 08 дугаар сарын сүүлийн 2 долоо хоног “Шинэ оюутанд туслах аян” хөтөч оюутнууд ажилладаг.

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгч нь элсэх эрхээ хангасан боловч хяналтын тоонд багтаагүй бол дараа жилийн элсэлтэд эрхтэй байдаг нь давуу тал болж болж байна. Шинэ оюутанд туслах аяныг зохион байгуулж, оюутан хөтөч ажиллуулдаг.

#### Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

#### Зөвлөмж:

- Өмнө хийгдсэн сурталчилгааны ажлын бодит үр дүнд судалгаа хийж элсэлтийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, элсэлтийн шалгалтын босго оноог нэмэгдүүлэх, орой болон эчнээ анги хичээллүүлэх замаар оюутны тоог нэмэгдүүлэх



## 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### Илрэл нотолгоо:

- *Бие хүний төлөвшил, харилцаа ёс зүйн чиглэлүүдээр сургалтуудыг явуулж хэвшиж иржээ. Түүнчлэн оюутанд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хүргэх, зөвлөх, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, хөдөлмөрийн ур чадвар мэдлэг мэдээлэл олгох сургалт, байнгын болон цагийн ажлын байрны зуучлал, ажил олгогч байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, мэдээллийн сан үүсгэх, оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг яармаг зохион байгуулах, тэтгэлэг хөнгөлөлт үзүүлэх, эрүүл мэнд, оюутны байрны үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй оюутныг дэмжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, оюутныг хөгжүүлэх судалгааны ажлын чадвар, дадал эзэмшүүлэх, оюутны төлөвшил, ёс зүй, харилцааг дээшлүүлэх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг явуулж байна <https://www.must.edu.mn/mn/OXYA-taniltsuulga>. Сургуулиас явуулж буй олон тооны лекцүүдэд геологийн хөтөлбөрийн багш нар идэвхтэй оролцжээ (С.Жаргалан, Г.Сэрсмаа)*

### Шалгуурыг хангасан байдал: **БҮРЭН ХАНГАСАН**

### Онцлог зүйл:

- *Оюутны хөгжил, соёл үйлчилгээний албанаас гадна тухайн жилийн элсэгчдийг хариуцсан геологийн ангийн зөвлөх багш нар оюутнуудыг төгсгөл оюутны тулгарсан асуудлуудад тогтмол зөвлөгөө өгч ажилладаг. Түүнчлэн оюутан солилцооны хөтөлбөрийн (International Association for the Exchange of students Technical Experience) дагуу гадаадын геологийн мэргэжлийн оюутнуудыг Монголд хээрийн дадлага хийлгэдэг байна.*

### Анхаарах асуудал:

### Зөвлөмж:

- *Оюутан суралцагчдын сургалт, хичээл сонголт, хөдөлмөр эрхлэлт, төгсөөд ажиллах ажлын байр болон бусад оюутнуудтай холбогдолтой ажлуудад зөвлөх багш гэж хязгаарлахгүйгээр геологийн хөтөлбөрийн багш нар жигд оролцох.*



### 5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн хэмжээнд болон геологи хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын дунд олон тооны сайн дурын клубууд үйл ажиллагаа явуулж оюутан залуусыг төлөвшүүлэх, багаар ажиллах чадвартай болгоход анхаарч дэмжлэг үзүүлж ирсэн байна. Түүнчлэн онцгой амжилт гаргасан оюутнуудад урамшуулал олгох, амьдралын боломж тааруу боловч олон нийтийн үйл ажиллагаа, мэргэжлийн болон бусад уралдаан тэмцээнд амжилт олсон оюутнуудад кредитийн урамшуулал олгодог. Нийт суралцагчдын 14,3%-иас 27,8% нь кредитийн урамшуулал авсан байна. Түүнчлэн зөвлөх багшийг томилон ажиллуулж, хичээл сонголтонд зөвлөх, сургалтын явцыг хянах ажлыг сургалтын албатай хамтран хэрэгжүүлдэг байна. Бакалавр, магистр болон докторантуудын эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж иржээ. Үүнд ахмад геологич Ж.Дүгэрсүрэнгийн нэрэмжит “Залуу судлаач” эрдэм шинжилгээний хурал, Голден Хилл ХХК-ны нэрэмжит оюутны эрдэм шинжилгээний хурлууд, жил бүр зохион байгуулагддаг Round Up геологичдын чуулга уулзалтад оюутан суралцагчид идэвхтэй оролцож ирсэн байна. Геологи хөтөлбөрийн багш нар нь өөрсдийн хэрэгжүүлдэг болон хамтран ажилладаг төслүүддээ оюутнуудыг оролцуулж тэдгээрээр дипломын ажлыг хийлгэдэг уламжлалтай байна. Ер нь геологи хөтөлбөрийн Геологи мэргэжлээр төгсөх оюутнууд нь төгсөлтийн ажлыг дипломын төсөл болон дипломын ажил гэсэн ерөнхий хоёр хэлбэрээс сонгон бичиж төгсдөг, дипломын төсөл бичсэн оюутны тоог судалгааны ажил бичсэн оюутны тоотой харьцуулахад нийт төгсөгчдийн 44,4%-иас 77,17% нь судалгааны ажил бичсэн байна. Харин Ковид19 цар тахлын үед онлайн сургалтыг явуулж, оюутнууд төгсөлтийн шалгалт өгч төгсжээ.
- Нотлох баримт: <https://www.must.edu.mn/mn/surdalt-damjaa-erdem-shinijilgee/>

#### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

#### Онцлог зүйл:

- Оюутнуудыг багш нар өөрсдийн оролцож ажилладаг төслүүдэд болон геологийн компаниудад хийсэн үйлдвэрлэлийн дадлагын материалууд дээр нь үндэслэн судалгааны ажлыг хийлгэж дипломын ажил бичиж хамгаалуулж байгаа нь ахисан түвшний сургалтад хамрагдах, өгүүлэл бичих, геологийн ажлын тайлан бичих зэрэгт бэлтгэгдэх ач холбогдолтой юм. Төгсөгч оюутнуудын дийлэнх хувь судалгааны ажил хийж байгаа нь онцлог байна.

*Амжилттай суралцсан оюутнуудад гадаад, дотоодын олон тооны тэтгэлэгүүд хангалттай байдаг.*

**Анхаарах асуудал:**

- *Мета клуб, гео-эрдэм клубуудыг үйл ажиллагааг улам эрчимжүүлэхэд багш нарын зүгээс илүү анхаарч, идэвхжүүлэн ажиллах (оюутны уулзалтаас)*

**Зөвлөмж:**

- *Судалгааны ажил бичиж буй оюутны тоог нэмэгдүүлэх*

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- *Геологи хөтөлбөрөөр суралцагчдын судалгаагаар сүүлийн 5 жилд 16 оюутан шилжих хөдөлгөөн, 142 оюутан хасагдсан байна. 16 оюутнаас 5 оюутан өөрийн хүсэлтээр шилжин ирсэн байхад 11 оюутан өөр мэргэжлээр суралцахаар шилжсэн, 142 оюутан чөлөөлөгдсөн байна. Оюутны хичээл дүйцүүлэлтийг ШУТИС-ийн захирлын 2014 оны 04 сарын 14 өдрийн А/64 тоот Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу дүйцүүлэлтийг хөтөлбөр хариуцсан профессорууд хийдэг байна.*

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл:**

- *Шилжилт хөдөлгөөнтэй хамт багц цагийн дүйцүүлэлтийг инженерийн мэргэжлийн ангиас болон гадаадын ижил мэргэжлийн сургуулиас шилжиж ирж буй бол дээд боловсролын суурь болон мэргэжлийн хичээлүүдийг шууд тооцдог, өөр мэргэжлийн сургуулиас ирсэн бол дээд боловсролын суурь болон адил төстэй хичээлүүдийг дүйцүүлэн тооцдог байна.*

**Анхаарах асуудал:**

- *Олон тооны суралцагчид өөр мэргэжил рүү шилжих, сургуулиас гарч, чөлөөлөгдөж байгаад анхаарч ажиллах*

**Зөвлөмж:**

- Оюутны өөр мэргэжил рүү шилжих болон чөлөөлөгдөх болсон шалтгаануудыг судлах

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн захирлын 2014 оны 04 сарын 14 өдрийн А/64 тоот тушаалаар батлагдсан Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 16-д заасан дээд боловсролын диплом олгох журмын дагуу төгсөгчдөд диплом, дипломын хавсралт, энгэрийн тэмдэг олгодог байна. Дипломд дипломын дугаар, төгсөгчийн овог нэр, регистрийн дугаар, төгссөн он, мэргэжлийн индекс, төгсөлтийн комиссын шийдвэр, тушаалын он сар өдөр бичигдсэн байх ба англи хувилбар нь Удирдах зөвлөлийн дарга, ШУТИС-ийн Захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан, цуглуулсан кредит, голч оноог үзүүлж, хавсралтад төгсөгчийн овог нэр, регистрийн дугаар, төгссөн он, мэргэжлийн индекс, мэргэжлийн нэр, диплом олгосон огноо, бүртгэлийн дугаар, судалсан хичээлүүд болон үйлдвэрлэлийн дадлагуудын нэр, кредит, оноо, үнэлгээ, судалсан нийт кредит, голч дүн, диплом хамгаалсан ажлын сэдэв гэсэн мэдээллүүд бичигддэг. Хавсралт нь дипломын хамт хүчинтэй байх тухай, үнэлгээний задаргаа, мөн мэргэжил нь БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн бол тэр тухай бичигдсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН****Онцлог зүйл:**

- 3.6 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй төгсөж байгаа төгсөгчдөд тухайн мэргэжлийн бакалаврын зэргийн “Онцлох” тусгай тэмдэг дарсан диплом олгохоос гадна тухайн мэргэжил нь БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн бол, тэрчлэн мэргэжлийн хөтөлбөр нь олон улсын мэргэжлийн байгууллагуудаар магадлан итгэмжлэгдсэн бол энэ тухай тэмдэглэлийг дипломд тусгаж өгдөг байна.

**Зөвлөмж:**

- ШУТИС-ийн Сургалт, цахим шилжилтийн газраас хийгдэж буй төгсөлтийн баримт бичгийг олон улсын жишигт нийцсэн байхаар шинэчлэн боловсруулах ажлаа дуусгах, хэрэгжүүлэх

**5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:****БҮРЭН ХАНГАСАН.**

## Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Багш, ажилтныг ажилд авахдаа ШУТИС-ийн захирлын 2021 оны 12-р сарын 14-ний А/232 тоот “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам” ([2021-12-14-a232-tushaal-hr-juram-new.pdf \(must.edu.mn\)](https://must.edu.mn)) тушаалаар шийдвэрлэх бөгөөд геологийн мэргэжлийн багш сонгон шалгаруулалт энэ журмын дагуу явагддаг. Геологи бакалаврын хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг заах үндсэн багш 13, бусад хөтөлбөр хэрэгжүүлж буй 9 багш, ерөнхий суурь хичээл заах багш 10 гаруй ажиллаж байгаагийн 86,3% нь эрдмийн зэрэг цолтой, ажилласан жил нь 11-54 жил ажилласан туршлагатай байна. Хичээлийн ачааллыг тухайн албан тушаалын зэрэглэлээс хамааран цагийн ачаалалтай харьцуулахад багш нарын ачаалал хэвийн байна. Тайлангийн хугацаанд нийт гавьяат багш 1 /Д.Чулуун/, алтан гадас одон 2 /Г.Сэрсмаа, С. Хишигсүрэн/, хөдөлмөрийн хүндэт медаль /Б. Мөнхцэнгэл/ болон боловсролын тэргүүн, тэргүүний геологич, жуух зэрэг шагналуудаар нийт 9 багш шагнагдсан байна. Түүнчлэн ШУТИС-ийн 2019 оны шилдэг судлаач багш /Б. Мөнхцэнгэл-2019/, “Web Of Science”-ШУТИС-ийн шилдэг судлаачийн /Б. Мөнхцэнгэл-2018, 2020/ шагналуудыг хүртсэн байна.

#### Онцлог зүйл/ Туршлага:

- Багш, ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадвар, үйлдвэрлэлийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогын хүрээнд докторантурт суралцаж байсан багш нарын цагийн ачаалал, сургалтын төлбөрийг нь тодорхой хувиар хөнгөлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх зэргээр эрдмийн зэрэг амжилттай хамгаалах боломж нөхцлийг нь хангаж өгчээ. Геологийн хөтөлбөрөөр ажиллаж буй багшлах бүрэлдэхүүний 86,3% нь докторын зэрэгтэй, геологийн салбартаа танигдсан нэртэй эрдэмтэд ажиллаж байгаа нь онцлог байна.

#### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн танилцуулга дээр 7 багшийн нэртэй танилцуулга гарч байгаа боловч тайлан дээр 9 багшийн нэр орсон, зарим багшийн нэр дутуу байна.

- Багшийн цагийн ачааллыг сүүлийн 4 жилийн байдлаар гаргасан хүснэгт 6,3-аас харахад 2022-2023 оны хичээлийн жилд багшийн цагийн ачаалал 96,95% байгаа шалтгааныг тайланд тусгаж өгөөгүй нотлох баримт материал байхгүй байна. Зарим багш нарын шагналын мэдээллүүдийг дутуу оруулсан байна.
- Тайлангийн хугацаанд 3 багш ажлаас гарсан, хэдийгээр эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн зохих ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөц бүрдүүлж чадсан байгаа ч, ажиллаж буй багш нарын ажилласан жилээс харахад дараагийн залуу үеэ бэлтгэх тал дээр анхаарах

### Үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

#### Зөвлөмж:

- Залуу үеэ /багшлах боловсон хүчээ/ бэлтгэх тал дээр тусгай бодлого гарган ажиллах

#### 6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх гол механизм нь багшийн хөгжил юм. ГУУС-ийн багшийн хөгжлийн 5 баг ажиллаж сургалтуудыг зохион байгуулдаг байна (<http://www.guus.edu.mn/mn/page/407>).
- Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо харилцан тохиролцож хамтын гэрээ байгуулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилладаг. ШУТИС-ийн хүний нөөцийн бодлогын 4.4.2-д заасны дагуу багш нар нь гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлдэгээс гадна ахмад багш нараас суралцах, багш хоорондоо мэдлэг туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлж өгч, нээлттэй хичээлүүдийн хийдэг байна. Тайлангийн хугацаанд нийт 14 багш Япон, АНУ, Энэтхэг, Хятад, Мянмар зэрэг улсуудын их дээд сургуулиуд болон хүрээлэнд мэргэжил дээшлүүлж, сурсан мэдсэн зүйлсээ бусадтай хуваалцаж, холбогдох сургалтуудыг хийж иржээ.

### Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

## Онцлог зүйл:

- ШУТИС-ийн Хүний нөөцийн бодлогын 4.4.2-ын “Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хувь хүнийг тасралтгүй, системтэй хөгжүүлэх” заалтын дагуу тус хөтөлбөрийн багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, ахмад багш нараас суралцах, багш нар хоорондоо мэдлэг туршлагаа хуваалцах үүднээс улирал бүр нээлттэй хичээл явуулдаг, гадаад, дотоодын сургалт семинаруудад тогтмол хамруулдаг байна.

## Зөвлөмж:

- Багш нарыг гадаадын нэртэй томоохон хурлуудад оролцож эрдэм шинжилгээний ажлаа хэлэлцүүлэхэд үзүүлэх дэмжлэгээ улам нэмэгдүүлэх,

### 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

## Илрэл нотолгоо:

- Геологи хөтөлбөрийн багш нар нь 9 эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Түүнчлэн 2018-2023 онуудад нийт 12 удаагийн гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалт, олимпиадыг зохион байгуулжээ. Нийт тайлангийн хугацаанд 2018-2022 онуудад гадаадын сэтгүүлүүдэд 37, дотоодын мэргэжлийн сэтгүүлүүдэд 32 өгүүллүүдийг хэвлүүлжээ. ШУТИС-ийн эрдэм шинжилгээний алба нь ([https://must.edu.mn/mn/erdem\\_shinжилgee/](https://must.edu.mn/mn/erdem_shinжилgee/)) бүтээлийн чөлөө олгох журам /2001 он/, ШУТИС-ийн дэд профессор, профессор цол олгох журам /2008 он/, ШУТИС-ийн Технологийн сангийн журам /2012 он/, ШУТИС-д Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам /2012 он/, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн журам /2012 он/, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн нийтлэг журам /2012 он/ журмуудыг баримтлан ажиллаж байна. Эрдэм шинжилгээний бодлого, төлөвлөлт нь ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх хөтөлбөр 2007-2015 он, МУ-ын Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, ШУТИС-2030 гэсэн хөтөлбөрүүдтэй байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

## Онцлог зүйл/Туршлага:

- Геологийн хөтөлбөрийн багш нарын хувьд УУХҮЯ-ны захиалгат болон ШУТСангийн суурь төслүүд, Улсын төсвийн төслүүдэд, геологийн



компаниудын захиалгат ажлуудыг хийдэг, зөвлөхөөр ажилладаг, түүндээ оюутан суралцагчдаа татан оролцуулдаг, олон тооны эрдэм шинжилгээний өгүүллүүдийг Web Of Science-д бүртгээлтэй нэр хүнд бүхий сэтгүүлүүдэд болон дотоодын сэтгүүлүүдэд хэвлүүлсэн, багш нарын бүтээлүүд нь эшлэгдсэн, ном сурах бичгүүдийг бичиж хэвлүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Нийт тайлангийн хугацаанд хэвлүүлсэн өгүүллүүдийн эшлэгдсэн байдлыг тайланд оруулж өгөөгүй байна (423 удаа эшлэгдсэн).
- Багш нарын боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгааг тайланд тусгагдаагүй байна (22 багшийн ном, сурах бичиг зохиогчийн эрхээр бүртгэгдсэн нотолгоо байна).
- Эрдэм шинжилгээний ажлын зарцуулсан төсвийг тайланд тусгасан боловч зарцуулалтын тайланг тусгаж өгөөгүй байна (Төсвийн зарцуулалтын тайлангууд хавсралтанд байна. Жишээ нь Субдукцын бүсийн геологи магматизм, хүдэржилтийн судалгаа, хэтийн төлөв тайлангийн санхүүгийн зарцуулалтын тайлан /2016-2018/, Нуурын бүсийн палеозойн магматизм төслийн санхүүгийн тайлан /2019-2022/ гэх мэт).

#### **Зөвлөмж:**

- Сургуулиас багш нарт гадаадын нэр хүнд бүхий хурал семинарт оролцох, өгүүлэл бичиж хэвлүүлэхэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Профессор багш нар нь албан тушаалын зэрэглэлээс хамааран жил бүрийн 9 сард ажлын төлөвлөгөө гарган батлуулж, 12 болон 5 сард ажлын төлөвлөгөөг тайлагнаж дүгнэдэг байна. Багшийн өөрийн үнэлгээний систем нь бүрэн цахимжсан байна /<http://sas.cloudmis.edu.mn/>. ШУТИС-ийн “Профессор багш нарыг аттестатчлах, профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох журам”-ыг Ректорын 2013 оны 11-р сарын А/213 тоот тушаалаар батлан мөрдлөг болгон ажилладаг, ШУТИС-ийн “профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож үнэлэх журам” журмын дагуу нийт профессор багш, ажилтнуудыг ажлын гүйцэтгэлийг үнэлж байна ([https://must.edu.mn/media/uploads/2022/10/03/8must\\_-.pdf](https://must.edu.mn/media/uploads/2022/10/03/8must_-.pdf)). Түүнчлэн

өөрийн үнэлгээний тайланг үндэслэн удирдлагын болон хөндлөнгийн үнэлгээ хийдэг. Хөндлөнгийн үнэлгээ нь хамтран ажилладаг хүмүүсийн үнэлгээгээр 0-5 хүртэл тоогоор үнэлж сар бүр ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 71%-иас дээш байвал 10 хүртэл хувиар, профессор багш, захиргааны ажилтанд улирал бүр тухайн албан тушаалын 1 сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар урамшуулал олгодог. Багшийн өөрийн үнэлгээний тайлан гаргах маягтай байна. Ажлын гүйцэтгэл 49%-ас доош байгаа тохиолдолд тухайн нэгжийн удирдлага ажил сайжруулах талаарх холбогдох арга хэмжээг хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг үндэслэн хариуцлага тооцох санал гаргадаг байна. Багш бүр өөрийн заадаг хичээлээр багшийн хавтас бүрдүүлдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн “профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож үнэлэх журам” журмын дагуу ([https://must.edu.mn/media/uploads/2022/10/03/8must\\_-.pdf](https://must.edu.mn/media/uploads/2022/10/03/8must_-.pdf)) ШУТИС-ийн профессор багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, сургууль, олон нийтийн үйлчилгээний ажлыг нэгтгэн үнэлдэг. Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ нь багш нарыг хөгжүүлэх, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, багш нарн албан тушаалын зэрэглэл, шатлал өөрчлөх, хөдөлмөрийн гэрээг сунгах, эс сунгах, тухайн профессорын баг, тэнхимийн талаар авах арга хэмжээг төлөвлөх, үйл ажиллагааг өргөжүүлэх, дэмжих, санхүү хөрөнгийн болон ажиллах хүчний нөөцөөр бэхжүүлэх, нэгтгэх, татан буулгах, тэргүүлэх профессор, тэнхимийн эрхлэгч нарын гэрээг сунгах, цуцлах, үр дүнгээр цалинжуулах, шагнал урамшуулалд дэвшүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг. ШУТИС нь Бүрэлдэхүүн сургуулиудын багш болон ажилтан нарыг ижил тэгш, үнэн бодитой үнэлэхийн тулд өөрийн үнэлгээний системийг нэвтрүүлэн ажиллаж, профессор багш нарт болон захиргааны ажилтанд улирал бүр урамшуулал олгодог байна.

#### **Анхаарах асуудал:**

- Зарим багш нарын багшийн хавтасыг гүйцээх

#### **Зөвлөмж:**

- Тайлангийн хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн болон гарсан багш нарын багшийн хавтасыг дараагийн магадлан итгэмжлэл хүртэл нотлох баримт болгон хадгалах

**6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**



## Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### Илрэл нотолгоо:

- ШУТИС нь Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний албатай байна.
- ШУТИС-ийн дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцооны гарын авлагатай, түүгээр үйл ажиллагаандаа хяналт тавьдаг.
- ГУУС-ийн 10 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг байна.
- ШУТИС нь олон улсын ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлдэг.
- Боловсролын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны 21001-2018 ШУТИС-ийн хэмжээн 2022 оны 12-р авсан. Өргөдөл гомдолыг бүх сувгаар авдаг. Сургалттай холбоотой өргөдөл гомдолыг сургалтын алба авдаг, Багштай холбоотойг хүний нөөцийн менежер авдаг.
- ГУУС-ийн Геологийн хөтөлбөрийн чанар баталгаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөөг боловсруулсан байна

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

#### Онцлог зүйл/Туршлага:

- Дотоод чанарын баталгаажуулалтын систем бий болсон байна.

### 7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### Илрэл нотолгоо:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, хичээлийн үнэлгээг хийсэн байна.
- Багшийн заах арга зүй, хичээлийн үнэлгээг хийсэн байна.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийсэн байна.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа хийсэн байна.
- Оролцогч талуудаас судалгаа авах төлөвлөгөө хувиар гаргаж хэрэгжүүлдэг байна.

- *Сэтгэл ханамжийн судалгааны тайланг хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж хөтөлбөрийг сайжуулдаг байна.*

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл/Туршлага:**

- *Оролцогч талуудын судалгааг авч хөтөлбөрийг хөгжүүлдэг жишиг тогтсон сайн талтай байна.*

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- *Үндэсний хэмжээнд 2011 онд магадлан итгэмжлэгдсэн.*
- *Ахиц дэвшлийн тайланг 2012, 2016 онуудад өгч байсан бөгөөд байнга шинэчлэн сайжруулж байсан байна.*
- *Гадаадын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг судалж хөтөлбөрийг боловсруулсан байна.*

**Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**

**Онцлог зүйл:**

- *Өмнө нь магадлан итгэмжлэгдсэн байна.*

**7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН  
ХАНГАСАН**

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
<b>Дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ШУТИС-ийн ГУУС-ийн “Геологи”-н бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... /Ж.МӨНГӨН/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Л.ЖАРГАЛ/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ц.НАРАНЦЭЦЭГ/

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг гадаадын 3-аас доошгүй хөтөлбөртэй харьцуулан судалж дүгнэх</li> <li>- Хөтөлбөрийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах</li> <li>- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг мэргэжлийн салбар, олон улсын мэргэжлийн байгууллагын эрхэм зорилго, зорилтуудтай уялдуулан тодорхойлох</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын төлөвлөгөөг хөтөлбөрт тавигдах шаардлага, холбогдох журмыг баримтлан бүтцийн хувьд оновчтой төлөвлөх</li> <li>- Сургалтын үйл ажиллагаандаа виртуал сургалтын үзүүлэн, орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан шинэлэг арга зүйг ашиглах</li> <li>- Шинэчилсэн хөтөлбөр буюу тайланд тусгасан хөтөлбөрөөр олгор ур чадвар, хичээлээр олгох ур чадваруудын уялдаа холбоог хангах</li> <li>- Хөтөлбөрөөр олгох ур чадварыг Блум таксономийн үйл үг ашиглан үнэлэх хэрэгтэй бөгөөд бакалаврын түвшинд 3 түвшний үйл үгнүүдийг ашиглан үнэлгээ хийдэг байхаар хичээлийн хөтөлбөрүүдэд тусгах</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутны бие даан болон багаар ажиллах орчны хангалтыг сайжруулах, цахим орчинд интернетийн хурдыг сайжруулах</li> <li>- Геологийн мэргэжлийн чиглэлийн сургалтын цахим контентүүдийг олшруулах</li> <li>- Оюутны эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх, үүнтэй холбоотойгоор номын сан, цахим мэдээллүүдийг ашиглахад оюутнуудын идэвх санаачилгыг сайжруулах</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутнуудын тоо цөөрч байгаатай холбоотойгоор Геологийн мэргэжлийг сурталчлах, хүүхэд залуусын сонирхлыг татах зорилгоор геологийн мэргэжлийн сурталчилгааг цахим хуудсаараа дамжуулан явуулах ажлыг эрчимжүүлэх</li> <li>- Төгсөгчдийг давтан сургах үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар явуулдаг байсан уламжлалыг сэргээх боломжийг судлах, явуулах</li> <li>- Геологийн мэргэжлийн чиглэлээр багш нарын бий болгосон гарын авлага, сурах бичгүүдийг олшруулах, төгсөгчид, геологичдод зориулан агуулгыг өргөжүүлэх, хэвлэх, худалдах замаар тодорхой хэмжээний орлогыг бий болгох</li> <li>- Оюутнуудын тоо цөөрч байгаатай холбоотойгоор арван жилийн сургуулийн ахлах ангийн сурагчдад геологийн мэргэжлийн сурталчилгааг цахим хуудсаараа дамжуулан явуулах ажлыг эрчимжүүлэх, ялангуяа мэргэжлийн</li> </ul>

	чиглэлийн танилцуулга-цахим контентүүдийг бий болгон сурталчлах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Өмнө хийгдсэн сурталчилгааны ажлын бодит үр дүнд судалгаа хийж элсэлтийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, элсэлтийн шалгалтын босго оноог нэмэгдүүлэх, орой болон эчнээ анги хичээллүүлэх замаар оюутны тоог нэмэгдүүлэх</li> <li>- Оюутан суралцагчдын сургалт, хичээл сонголт, хөдөлмөр эрхлэлт, төгсөөд ажиллах ажлын байр болон бусад оюутнуудтай холбогдолтой ажлуудад зөвлөх багш гэж хязгаарлахгүйгээр геологийн хөтөлбөрийн багш нар жигд оролцох</li> <li>- Судалгааны ажил бичиж буй оюутны тоог нэмэгдүүлэх</li> <li>- Оюутны өөр мэргэжил рүү шилжих болон чөлөөлөгдөх болсон шалтгаануудыг судлах</li> <li>- ШУТИС-ийн Сургалт, цахим шилжилтийн газраас хийгдэж буй төгсөлтийн баримт бичгийг олон улсын жишигт нийцсэн байхаар шинэчлэн боловсруулах ажлаа дуусгах, хэрэгжүүлэх</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Залуу үеэ /багшлах боловсон хүчээ/ бэлтгэх тал дээр тусгай бодлого гарган ажиллах</li> <li>- Багш нарыг гадаадын нэртэй томоохон хурлуудад оролцож эрдэм шинжилгээний ажлаа хэлэлцүүлэх, өгүүлэл бичиж хэвлүүлэхэд үзүүлэх дэмжлэгээ улам нэмэгдүүлэх</li> <li>- Тайлангийн хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн болон гарсан багш нарын багшийн хавтасыг дараагийн магадлан итгэмжлэл хүртэл нотлох баримт болгон хадгалах</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	

## IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

### I. Суралцагчдын нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Ч.Анхбаяр	4	Голч оноо	80331960
2	Б.Тэргэлболд	4	Голч оноо	99072786
3	Б.Тогтохням	4	Эмэгтэй, төгсөх анги	80840702
4	Х.Ууганжаргал	4	Оюутны байр	88814586
5	Л.Тилеуберди	3	Орон нутаг, голч оноо	99427092
6	А.Жавхлан	3	3-р курс	96664638
7	Б.Тэмүүлэн	3	Улаанбаатар	80337345
8	Ц.Ариунболд	3	Орон нутаг	95762493
9	М.Бадамханд	2	Зорилтот элсэгч, оюутны байр	86135144
10	Э.Энхмөнхбаатар	2	Хөдөө орон нутаг	85519694
11	О.Ижилмөрөн	2	Хөдөө орон нутаг	93136883
12	Г.Эрдэнэбат	2	Улаанбаатар	95226988
13	Б.Буянхишиг	1	Шинэ элсэгч	90144389
14	Ч.Баярмаа	1	Шинэ элсэгч	90711701
15	Д.Эрхэм	1	Шинэ элсэгч	80381524
16	Б.Дөлгөөн	1	УЗН гишүүн	95348915

### II. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	Н.Баянмөнх	Тригтек компанийн ерөнхий геологич	88110773
2	Д.Алтанхуяг	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий геологич	99351673
3	Ч.Өлзийбаяр	Оюу толгой ХХК-ний ахлах геологич	86861636
4	Б.Уянга	УУХҮ-ийн сайдын зөвлөх	86117002
5	Г.Ганбаяр	Гурван талст ХХК-ийн гүйцэтгэх захирал	80968016
6	Н.Тунгалаг	ШУА-ийн Геологийн хүрээлэн, ЭНБД	99879996
7	С.Төмөр	Монголын Алт ХХК-ийн төслийн удирдагч	99064228
8	Ж.Тогтох	Геоэрин ХХК-ны ерөнхий геологич	99035528
9	Э.Батмөнх	Магма майнс ХХК-ны захирал	99113080
10	С.Лхагва-Очир	Энержи ресурс компанийн үйл ажиллагаа харицсан дэд ерөнхийлөгч	88117002

### III. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	Ц.Нинжин	2018	Оюу толгой ХХК-д геологич	99126450
2	П.Баатарбилэг	2018	Үндэсний геологийн алба	99899088
3	Б.Нямзаяа	2018	Геологийн мэдээллийн архив	85114149
4	Ц.Баясгалан	2019	Гурван Үндэс ХХК-д геологич	89047455
5	Н.Гангааням	2019	Айлбаян нүүрсний уурхайд геологич	99760033
6	Э.Эрдэмтөгс	2020	Терра энерги компанид геологич	80448944, 85158944
7	Г.Базарсад	2021	Тригтек ХХК-д геологич	88645561
8	Х.Отгон-Үенч	2021	Тригтек ХХК-д геологич	86255004
9	В.Банзрагч	2022	Менторис ХХК-д геологич	89472287
10	Ж.Эрдэнэдалай	2023	Голден Хилл ХХК-д геологич	80722109
11	Т.Номин	2023	Тохоку их сургуулийн магистрант	86161961

#### IV. Уулзалтад оролцсон багш нарын мэдээлэл

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1	Г.Сэрсмаа	Дэд проф.	Палеонтологи, стратиграфийн үндэс, Түүхэн геологи, Региональ ба Монголын геологи	99155884
2	С.Хишигсүрэн	Дэд проф.	Ерөнхий геологи, Геодинамик	99170801
3	Б.Мөнхцэнгэл	Проф.	Геохими, Петрологи	99916817
4	Б.Батхишиг	Чанарын менежер	Ашигт малтмалын үндэс, Метал ашигт малтмал, Магмын ба хувирмал чулуулугийн петрологи	99841522
5	Ж.Ундаръяа	Ахлах багш	Палеонтологи, стратиграфийн үндэс, Түүхэн геологи, Седиментологи	99078501
6	О.Мөнхцэцэг	ЭНБД	Структур геологийн үндэс, Геологийн зураглалын арга	88056491
7	Д.Хишигсүрэн	Багш	Структур геологийн үндэс, Геологийн зураглалын арга, Минеарлоги петрографийн үндэс, Минералоги	99056835

## V. ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГААС ИРСЭН САНАЛ

/албан бичгийг оруулах/



### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ

Бага тойруу 34, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас/Факс: (976-11) 31 22 91,  
Цахим шуудан: guus.info@must.edu.mn,  
Цахим хуудас: www.guus.edu.mn

2023.12.22 № 359.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Геологи, гидрогеологийн салбарын "Геологи" бакалаврын сургалтын хөтөлбөрийн шинжээчийн багийн үнэлгээний тайланг 2023 оны 12-р сарын 19 -ний өдөр цахимаар хүлээн авч танилцсан болно. Тус хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд бичигдсэн дүгнэлт, зөвлөмжүүдийг хүлээн зөвшөөрч хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тусган ажиллах болно.



ЗАХИРАЛ

К. ХАВАЛБОЛОТ

367770555